

ИЛ БОЛСОН

МАШ НУУЦ



ТАВАНТОЛГОЙ ТӨМӨР ЗАМ ХХК
“ТАВАНТОЛГОЙ ТӨМӨР ЗАМ”
ХЯЗГААРЛАГДМАН ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИ

болон

ӨМГӨӨЛЛИЙН “ЛЕГАЛ ЛИНК СИ БИ ЭЙ”
ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ НӨХӨРЛӨЛ

нарын хооронд байгуулсан

ХУУЛИЙН ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ГЭРЭЭ

Гэрээний дугаар: *ТТЗ-МН22/06*

2022 оны 08 дугаар сарын 30-ний өдөр

Улаанбаатар хот

ХУУЛИЙН ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ГЭРЭЭ

2022 оны ... дугаар
сарын ...-ны/ний өдөр

Дугаар:

Улаанбаатар
хот

Энэхүү гэрээг (цаашид "Гэрээ" гэх) Монгол Улсын Иргэний хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.4 дэх хэсэг Засгийн газрын 2019 оны 196 дугаар тогтоол, Тагнуулын Ерөнхий газрын 2020 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн 76 тоот албан бичиг, Тагнуулын Ерөнхий газрын 2021 оны 09 дүгээр сарын 07-ны өдрийн 21/129 дугаартай Аюулгүй байдлын гэрчилгээ, "Тавантолгой төмөр зам" ХХК-ийн Төслийн хорооны 2022 оны 07 дугаар сарын 29-ны өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн,

Нэг талаас Монгол Улс, Улаанбаатар хот 14230, Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо, 13 дугаар хороолол, Нарны зам 62, "Юнион Бюлдинг" Б блок, 11 давхар"-т байрлах "Тавантолгой төмөр зам" ХХК /цаашид "Захиалагч" гэх/,

Нөгөө талаас Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо, 13 дугаар хороолол, Нарны зам 62, "Юнион Бюлдинг" С блок, 10 давхар 1008 тоот" хаягт байрлах "Өмгөөллийн Легал Link Си Би Эй" ХХН /цаашид "Зөвлөх" гэх/ нар байгуулав.

1. Зөвлөх нь энэхүү гэрээ болон гэрээний салшгүй хэсэг болох Хавсралт №1-д тодорхойлсон "Ажлын даалгавар"-т заасан зөвлөх үйлчилгээг (цаашид "үйлчилгээ" гэх) мэргэжлийн өндөр түвшинд үзүүлэх үүрэгтэй.

2. Энэхүү гэрээгээр Зөвлөх тал нь Захиалагчид шаардлагатай хавсралтад заасан ажлуудаар зөвлөх үйлчилгээг үзүүлэх, цаг үеийн шинжтэй асуудлаар Захиалагчийн нэрийн өмнөөс шаардлагатай хуулийн зөвлөх үйлчилгээгээр хангах, Захиалагч тал нь гүйцэтгэсэн ажлын хөлсийг төлөхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулна.

3. Хуулийн зөвлөх үйлчилгээг (цаашид "ажил" гэх) 11,115,000,000 /Арван нэгэн тэрбум нэг зуун арван таван сая/ төгрөгийн үнийн дүнгээр 4 (дөрвөн) жилийн хугацаатайгаар гүйцэтгэхээр тохиролцов. Гэрээний үнэ буюу ажлын нийт төсөвт өртөг нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.

4. Дор дурдсан бичиг баримт нь гэрээний хэсэг болно (цаашид "гэрээний баримт бичиг" гэх). Үүнд:

- I. Гэрээний ерөнхий нөхцөл;
- II. Гэрээний тусгай нөхцөл;
- III. Хавсралт

Хавсралт №1 Ажлын даалгавар;

Хавсралт №2 Гэрээний төлбөр, төлбөрийн хуваарь;

Хавсралт №3 Ажлын календарчилсан төлөвлөгөө

Гэрээ нь энд дурдсан Зөвлөх үйлчилгээг гүйцэтгэх талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болно.

5. Захиалагч болон Зөвлөх нь гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлд заасан эрх, үүрэг, хариуцлагыг хүлээнэ.

6. Зөвлөх нь гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан ажлыг гүйцэтгэж, зөрчил, гологдол арилгах үүрэг хариуцлагыг хүлээнэ.



7. Захиалагч нь гэрээний дагуу Зөвлөхийн хийх ажил болон зөрчил, гологдол арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний төлбөрийг гүйцэтгэгчид төлөх үүрэг хариуцлага хүлээнэ.

8. Гэрээг 2 хувь үйлдэх ба талууд гарын үсэг зурж, баталгаажуулан Захиалагч талаас гэрээний дугаарыг олгосноор гэрээ түүний нэмэлт өөрчлөлт, хүчин төгөлдөр болно.

9. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр болон утсан холбоогоор харилцана.

10. Талуудын хооронд байгуулсан 2021 оны 06 дугаар сарын 01-ны өдрийн “Төрийн болон албаны нууцад хамаарах мэдээ, мэдээллийг хадгалах хамгаалах шилжүүлэх гэрээ” нь энэхүү гэрээний хүрээнд сунгагдсанд тооцно.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

“ТАВАНТОЛГОЙ ТӨМӨР ЗАМ” ХХК-
ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



И.УДААНЖАРГАЛ/

Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
1 дүгээр хороо, 13 дугаар хороолол,
Нарны зам 62, “Юнион Бюлдинг” Б блок,
11 давхар

Холбоо барих: 77777727

ЗӨВЛӨХИЙГ ТӨЛӨӨЛЖ:

ӨМГӨӨЛЛИЙН “ЛЕГАЛ ЛИНК СИ БИ ЭЙ” ХХН-
ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



ӨМГӨӨЛЛИЙН
ЛЕГАЛ ЛИНК
СИ БИ ЭЙ

/Л.ОТГОНБАЯР/

9020060621
УЛААНБААТАР ХОТ

Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р
хороо, Нарны зам-62, Юнион Бьюлдинг С блок
10 давхар 1008 тоот

Холбоо барих: 99117720, 99108955



ИЛ БОЛСОН

МАШ НУУЦ

I. ХУУЛИЙН ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ
НӨХЦӨЛ



1. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

<p>1.1. Нэр томъёоны тодорхойлолт</p>	<p>Энэ гэрээнд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:</p> <ul style="list-style-type: none"> (а) "Гэрээнд хэрэглэх хууль" гэж ГТН-д заасан Монгол улсын хүчин төгөлдөр хууль болон бусад эрх зүйн актыг хэлнэ. (б) "Зөвлөх" гэж хууль зүйн зөвлөх үйлчилгээг үзүүлж буй хуулийн этгээдийг хэлнэ. (в) "Гэрээ" гэж талуудын гарын үсэг зурсан гэрээний маягт болон түүнд дурдсан бусад баримт бичгүүд болох Гэрээний ерөнхий нөхцөл, Гэрээний тусгай нөхцөл болон хавсралт баримт бичгүүдийг хэлнэ. (г) "Хоног" гэж хуанлийн хоногийг хэлнэ. (д) "Гэрээ хүчин төгөлдөр болох огноо" гэж ГЕН-ийн 2.1-д заасан гэрээ хүчин төгөлдөр болох огноог хэлнэ. (е) "Гэрээний үнэ" гэж ГЕН-ийн 6 дугаар зүйлд заасны дагуу Үйлчилгээний гүйцэтгэлийн төлөө Зөвлөхөд төлөх төлбөрийн хэмжээг хэлнэ. (ё) "ГЕН" гэж Гэрээний ерөнхий нөхцөлийг хэлнэ. (ж) "Гэрээний тал гэж" Захиалагч эсхүл Зөвлөхийн аль нэгийг, харин "Талууд" гэж хоёуланг нь хэлнэ. (з) "ГТН" гэж гэрээний ерөнхий нөхцөлийг тодотгож байгаа Гэрээний тусгай нөхцөлийг хэлнэ. Гэрээний ерөнхий нөхцөлд зааснаас өөрөөр тусгай нөхцөлд заасан бол тусгай нөхцөлийн заалтыг мөрднө. (и) "Үйлчилгээ" гэж Хавсралт №1-т тодорхойлсон, энэхүү гэрээнд заасны дагуу Зөвлөхийн хийж гүйцэтгэвэл зохих ажлыг хэлнэ. (й) "Туслан гүйцэтгэгч" гэж үйлчилгээний аль нэгэн хэсгийг туслан гүйцэтгэхээр Зөвлөхтэй гэрээ байгуулсан хувь хүн, хуулийн этгээдийг хэлнэ. (к) "Ажиллах хүчин" гэж Үйлчилгээ буюу түүний аль нэгэн хэсгийг гүйцэтгүүлэхээр Зөвлөхийн эсхүл туслан гүйцэтгэгчийн хөлсөлсөн хувь хүнийг хэлнэ.
<p>1.2. Гэрээнд хэрэглэгдэх хууль</p>	<p>Энэхүү гэрээ, түүний агуулга болон тайлбар, мөн талуудын харилцааг ГТН-д заасан хууль тогтоомжоор зохицуулна.</p>
<p>1.3. Гэрээнд ашиглах хэл</p>	<p>Энэхүү гэрээ нь ГТН-д заасан улсын хэл дээр боловсруулагдсан бөгөөд гэрээний агуулга, тайлбартай холбоотой бүх асуудалд уг хэлийг ашиглана. Талууд хоорондын харилцах бичиг баримт нь энэ хэл дээр байна.</p>
<p>1.4. Мэдэгдэл</p>	<p>Энэхүү гэрээний дагуу олгогдсон эсхүл шаардагдах аливаа мэдэгдэл, хүсэлт буюу зөвшөөрөл зэргийг бичгээр үйлдсэн байх ёстой. Эдгээр мэдэгдэл, хүсэлт буюу зөвшөөрөл нь харилцаж байгаа талын итгэмжлэгдсэн төлөөлөгчид биечлэн хүргэгдсэн эсхүл ГТН-д заасан хаягаар илгээсэн тохиолдолд олгогдсон гэж тооцогдох ёстой.</p>



1.5. Байршил	Үйлчилгээг Захиалагчийн тодорхойлж өгсөн нутаг дэвсгэрт хэрэгжүүлнэ.
1.6. Итгэмжлэгдсэн төлөөлөгч	Гэрээний дагуу захиалагч эсхүл зөвлөхийн гүйцэтгэвэл зохих аливаа үйл ажиллагаа болон баримт бичгийг ГТН-д заасан албан тушаалтан хариуцан хийнэ.
1.7. Татвар, хураамж	Зөвлөх, туслан гүйцэтгэгч болон тэдгээрийн ажиллах хүчин нь ГТН-д заасан гэрээнд хэрэглэх хуулийн дагуу төлбөл зохих татвар, хураамж болон төлбөрийг төлөх ёстой.
1.8. Авиалгал болон залилан мэхлэх үйлдэл	Захиалагчийг төлөөлөн гэрээнд оролцож байгаа ажилтан болон бусад оролцогч, гэрээ хэрэгжүүлэгч зөвлөх бүр гэрээ байгуулах, гэрээг үйлдэл хэрэгжүүлэхдээ ёс суртахууны өндөр хэм хэмжээг сахин биелүүлэх ёстой. Талууд нь Авиалгын эсрэг хууль, Өрсөлдөөний тухай хууль болон Эрүүгийн хуульд заасан авиалгал, залилан мэхлэх, зохиомол тохиролцоо хийх, айлган сүрдүүлэх үйлдлийн аль нэгэнд холбогдсон талаар бодитой мэдээлэл байгаа бол холбогдох албан тушаалтан, хууль хяналтын байгууллагад зохих ёсоор мэдэгдэнэ.

2. ГЭРЭЭНИЙ ҮҮРГИЙГ ЭХЛҮҮЛЭХ, ГҮЙЦЭТГЭХ, ДУУСГАВАР БОЛГОХ, ТҮҮНД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ БОЛОН ЦУЦЛАХ

2.1. Гэрээ хүчин төгөлдөр болох	Энэхүү гэрээ нь холбогдох зөвшөөрлийг үндэслэн талуудын төлөөлөх эрх бүхий этгээдүүд гарын үсэг зурсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно. Гэрээг хүчин төгөлдөр болох өдрийг гэрээ хүчин төгөлдөр болох огноо гэж ойлгоно.
2.2. Үйлчилгээг эхлэх	Зөвлөх нь гэрээ хүчин төгөлдөр болсноос хойш ГТН-д заасан хоногт багтаан үйлчилгээг эхлэх ёстой.
2.3. Гэрээний хугацаа дуусгавар болох	ГЕН-ийн 2.6-д заасны дагуу цуцлагдаагүй бол гэрээ хүчин төгөлдөр болсноос хойш ГТН-д заасан хугацааны дараагаар энэхүү гэрээний хугацаа дуусгавар болно.
2.4. Гэрээний өөрчлөлт буюу сайжруулах	Гэрээний нөхцөл, ажлын даалгаварт оруулах өөрчлөлт, засварыг гагцхүү бичгээр үйлдэн талууд харилцан тохиролцож, гарын үсэг зурж баталгаажуулсан тохиолдолд гэрээний нөхцөл, болзол болон ажлын цар хүрээг засварлах, эсхүл өөрчилж болно. Ажлын даалгаварт нэмэлтээр ажил оруулахаар бол тус нэмэлт ажилд төлөх хөлсний талаар харилцан тохиролцох ба нэмэлт ажил эхлэхээс өмнө Гэрээний үнэд өөрчлөлт оруулна.



2.5. Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл

2.5.1. Дайн, иргэний бослого, түймэр, үер, халдварт өвчин, газар хөдлөлт, хорио цээр, цар тахал, тээврийн хориг болон бусад гэнэтийн болон давагдашгүй хүчиний нөхцөл байдал үүссэнээс Талуудаас гэрээний үүргийн гүйцэтгэл хугацаа хоцорсон бол харилцан тохиролцон гүйцэтгэх хугацааг сунгана.

2.5.2 Гэнэтийн болон давагдашгүй хүчиний нөхцөл байдал үүссэн тохиолдолд Зөвлөх нь энэ нөхцөл байдал болон үүссэн шалтгааны талаар захиалагчид нэн даруй бичгээр мэдэгдэнэ. Захиалагч бичгээр өөрөөр зааварлаагүй бол Зөвлөх гэрээний үүргээ боломжтой хэмжээнд үргэлжлүүлэн гүйцэтгэж, гэнэтийн болон давагдашгүй хүчиний нөхцөл байдлаас үл шалтгаалан гэрээг хэрэгжүүлэх боломжит арга замыг хайна. Энэхүү зүйлд заасан дараах нөхцөл байдал үүссэн тохиолдолд захиалагч өөрийн санаачлагаар гэрээг цуцлах эрхтэй.

2.6. Гэрээ цуцлах
2.6.1. Захиалагч гэрээг цуцлах

- a) Зөвлөх гэрээний дагуу хүлээсэн үүргээ зөрчсөн талаарх мэдэгдлийг хүлээн авсны дараагаар 30 хоног, эсхүл Захиалагчийн бичгээр зөвшөөрөн сунгасан хугацаанд багтаан мэдэгдэлд дурдсан зөрчлийг арилган үүргийн гүйцэтгэлийг хангаагүй;
- b) Зөвлөх (эсхүл түншлэлийн аль нэг гишүүн) төлбөрийн чадваргүй болсон, эсхүл дампуурсан, эсхүл дампуурлаас зайлсхийх зорилгоор зээлдүүлэгчтэй тохиролцсон, эсхүл сайн дураараа буюу албадан журмын дагуу татан буугдаж байгаа;
- v) Зөвлөх нь гэрээ байгуулах буюу гэрээг гүйцэтгэх явцдаа авилгал, залилан мэхлэх үйлдэлд холбогдсон байж болох хангалттай үндэслэл захиалагчид байгаа;
- (g) Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл үүссэний улмаас Зөвлөх нь 60-аас дээш хоногийн хугацаанд үйлчилгээний голлох хэсгийг гүйцэтгэх боломжгүй болсон;
- (d) Захиалагч өөрийн санаачилгаар дээр зааснаас бусад үндэслэлээр гэрээг цуцлахаар шийдвэрлэсэн бол;

2.6.2. Зөвлөхийн санаачлагаар гэрээг цуцлах

Энэхүү зүйлд заасан дараах нөхцөл байдал үүссэн тохиолдолд Зөвлөх өөрийн санаачлагаар гэрээг цуцлах эрхтэй.

- (a) Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл үүссэний улмаас Зөвлөх нь 60-аас дээш хоногийн хугацаанд үйлчилгээний голлох хэсгийг гүйцэтгэх боломжгүй болсон;
- (b) Захиалагч гэрээний дагуу хүлээсэн үүргээ ноцтой зөрчсөн бөгөөд энэхүү зөрчлийн талаарх мэдэгдлийг хүлээн авснаас хойш 45 хоногийн хугацаанд (эсхүл Зөвлөхийн бичгээр зөвшөөрөн сунгасан хоногт багтаан) тухайн зөрчлийг арилгаагүй.

3. ЗӨВЛӨХИЙН ХҮЛЭЭХ ҮҮРЭГ

3.1 . Ерөнхий зүйл	Зөвлөх нь гэрээний дагуу гүйцэтгэвэл зохих үүрэг болон үзүүлэх үйлчилгээг нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн мэргэжлийн болон бодит жишигт нийцүүлэн үр ашигтай, хэмнэлттэй байдлаар гүйцэтгэх ёстой бөгөөд гүйцэтгэлийн чанарыг Захиалагчийн өмнө бүрэн хариуцаж, үйл ажиллагааны шуурхай удирдлагыг ханган ажиллах ёстой.
3.1.1 . Гүйцэтгэлийн чанар	Зөвлөх нь гэрээ болон үйлчилгээтэй холбоотой ямарваа нэгэн асуудлаар ямагт Захиалагчийн зөвлөхийн хувиар хандан ажиллах бөгөөд туслан гүйцэтгэгч буюу гуравдагч этгээдтэй хийх аливаа харилцаанд захиалагчийн хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах ёстой.
3.2. Ашиг сонирхлын зөрчил	Зөвлөх нь ирээдүйд хийх ажилтай холбоотой ямар нэгэн зүйлийг үл харгалзан Захиалагчийн ашиг сонирхлыг нэн тэргүүнд тавих ёстой бөгөөд Захиалагчийн эрх ашигтай, сонирхлын зөрчилд орохос зайлсхийх ёстой.
3.3. Нууцлал	Зөвлөх болон түүний ажилтан, зөвлөхтэй гэрээ хэлцэл байгуулан ажиллаж буй этгээд нь гэрээний төрийн болон албаны нууцад хамаарах мэдээ, мэдээллийг хадгалах, хамгаалах, шилжүүлэх гэрээнд заасны дагуу нууцлалыг хамгаална.
3.4. Зөвлөхийн хариуцах даатгал	Зөвлөх нь захиалагчийн зөвшөөрсөн нөхцөл, болзлын дагуу болон ГТН-д тусгайлан заасан эрсдэлд хамаарах даатгалыг өөрийн зардлаар хариуцан хийлгэх бөгөөд даатгалын гэрээ, гэрчилгээг Захиалагчид ирүүлнэ. Тусгай нөхцөлд тусгайлан заагаагүй тохиолдолд даатгалын гэрээ байгуулахгүй байж болно.
3.5. Захиалагчаас урьдчилтан зөвшөөрөл авбал зохих үйл ажиллагаа	Зөвлөх нь дор дурдсан үйл ажиллагааг явуулахаас өмнө захиалагчийн зөвшөөрлийг бичгээр авсан байх ёстой. Үүнд:
	(а) ГТН-д тусгайлан заасан бусад үйл ажиллагаа, (б) Захиалагчийн хэрэгжүүлж буй үйл ажиллагаатай холбоотой аливаа үйл ажиллагаанд гэрээнээс гадуур оролцох, дээрх ажилтай холбоотойгоор бусад этгээдтэй гэрээ, хэлцэл, контракт байгуулах.
3.6. Тайлгнах хуваарь	Зөвлөх нь Захиалагчид үзүүлсэн үйлчилгээний талаарх тайлан болон баримт бичгийг тухайн сард ажилласан удирдлага зохион байгуулалт, багийн гишүүдийн чиг үүрэг, шаардлагатай гэж үзсэн тохиолдолд үйлчилгээний явцад үүссэн хүндрэл, шийдвэрлэх асуудлууд, мөн ажлын явцад нөлөө үзүүлж буй хүчин зүйлсийн жагсаалтын хамт сар бүрийн 05-ны өдрийн дотор хүргүүлэх ёстой. Мөн Захиалагчаас шаардсан тухай бүр холбогдох мэдээлэл, тайланг хүргүүлэн ажиллана.
3.7. Зөвлөхийн боловсруулсан баримт бичиг Захиалагчийн өмч болох нь	Энэхүү гэрээний дагуу Захиалагчид зориулж Зөвлөхийн боловсруулсан аливаа судалгаа, тайлан материал, эд зүйл нь захиалагчийн өмч болж үлдэх бөгөөд гэрээний тайлант хугацаа болон гэрээг дуусгавар болох, гэрээ цуцлахаас өмнө эдгээр материалыг дэлгэрэнгүй жагсаалтын хамтаар Захиалагчид хүргүүлнэ. Зөвлөх нь эдгээр бичиг баримт болон программ хангамжийн хувийг авч болно.
3.8. Нягтлан бодох бүртгэл , Хяналт	Зөвлөх нь гэрээний гүйцэтгэлд хамаарах нягтлан бодох данс, бүртгэлийг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн зарчмын дагуу хөтлөн явуулах бөгөөд

шалгалт болон
Аудит

Захиалагч түүний томилсон төлөөлөгч эсхүл аудитор эдгээр данс, бүртгэлд хөндлөнгийн шалгалт хийх эрхтэй.

4. ЗӨВЛӨХИЙН АЖИЛТНУУД

4.1. Ажиллах хүчний тодорхойлолт	Зөвлөх үйлчилгээ үзүүлэх багийн бүрэлдэхүүн, чиг үүргийн хуваарилалт, санал болгож буй гол мэргэжилтэн бүрийн танилцуулга, хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэхтэй холбоотой зөвшөөрөл зэргийн талаарх мэдээллийг Хавсралт №1-т тусгана.
4.2. Нэмэлт үүрэг	Захиалагчийн хүсэлтийн дагуу Зөвлөх нь Ажлын цар хүрээ буюу Ажлын даалгаварт тодорхой заагаагүй боловч Захиалагчийн үйл ажиллагаанд хамаарах асуудлаар чиг үүргийг гүйцэтгэн ажиллаж болно.

5. ЗАХИАЛАГЧИЙН ХҮЛЭЭХ ҮҮРЭГ

5.1. Дэмжлэг үзүүлэх болон зөвшөөрөл олгох	Захиалагч нь ГТН-д заасан зөвлөхөд үзүүлэх дэмжлэг, туслалцаа болон холбогдох зөвшөөрлийг төрийн эрх бүхий байгууллагын зүгээс олгуулах бүх талын дэмжлэгийг үзүүлнэ.
5.2. Гэрээнд хэрэглэх хуулинд татвар	Хэрэв, гэрээ байгуулагдсанаас хойш гэрээнд хэрэглэх хуулинд татвар, хураамжийн талаар орсон өөрчлөлтийн улмаас үйлчилгээний гүйцэтгэлийн дагуу Зөвлөхийн хүлээн авах төлбөр нэмэгдэх буюу хасагдахаар байгаа хураамжийн талаар орсон өөрчлөлт бол талууд тохиролцон гэрээний дагуу Зөвлөхөд төлөх цалин болон нөхөн төлөгдөх зардлын хэмжээг өөрчлөх бөгөөд энэхүү холбогдох үнийн тохируулга нь ГЕН-ийн 6.2 (а), (б)-д заасан төлбөрийн хэмжээнд нийцсэн байх ёстай.
5.3. Захиалагчийн зүгээс үзүүлэх үйлчилгээ, тоног төхөөрөмж болон эд хөрөнгө	Захиалагч нь ажлыг хугацаанд нь чанартай хэрэгжүүлэх зорилгоор үйлчилгээ, тоног төхөөрөмж болон шаардлагатай материлагы Зөвлөхөд гарган өгч болно. Мөн ГТН-д заасан арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

6. ЗӨВЛӨХӨД ТӨЛӨХ ТӨЛБӨР

6.1. Нийт төлбөр	Зөвлөхөд төлөх нийт төлбөрийн хэмжээ нь гэрээний Хавсралт №1-т тодорхойлсон үйлчилгээг үзүүлэхэд шаардагдах бүх зардлыг тооцсон тогтмол нийт үнийг багтаасан гэрээний үнээс хэтрэх ёсгүй. ГЕН-ийн 5.2-т заасны дагуу өөрчилснэөс бусад тохиолдолд ГЕН-ийн 6.2-т тодорхойлсон үнийн хэмжээг гагцүү ГЕН-ийн 2.4-т зааснаар талууд нэмэлт төлбөр хийхийг зөвшөөрсөн тохиолдолд нэмэгдүүлж болно.
6.2. Гэрээний үнэ	(а) Гадаад мөнгөн тэмдэгтээр хийх төлбөрийн хэмжээг ГТН-д тодорхойлно. (б) Төгрөгөөр хийх төлбөрийн хэмжээг ГТН-д тодорхойлно.
6.3. Нэмэлт үйлчилгээний төлбөр	ГЕН-ийн 2.4-т заасны дагуу төлөхөөр зөвшөөрч болох нэмэлт үйлчилгээний цалингийн хэмжээг тодорхойлохын тулд нийт үнийн задаргааг Хавсралт №3-д оруулна.



6.4. Төлбөр хийх нөхцөл. Хуваарь

Төлбөрийг ГТН-д заасан төлбөр хийх хуваарийн дагуу, тэнд заасан Зөвлөхийн дансанд хийнэ. Зөвлөхийн урьдчилгаа төлбөрт хийж гүйцэтгэх ажлын баталгаа болгон ГТН-д заасан төлбөрийг урьдчилгаа төлбөрөөс хасч шилжүүлнэ. ГТН-д заасан нөхцөл болзлыг хангасны дараа, зөвлөхөд төлбөл зохих төлбөрийн хэмжээг тодорхойлсон нэхэмжлэлийг Захиалагчид ирүүлснээр бусад төлбөр хийгдэх ёстай.

6.5. Хугацаа хоцорсон төлбөрийн хүү

Захиалагч нь ГТН-ийн 6.4-д тогтоосон төлбөр хийх хугацааг арван таван (15) дээш хоногоор үндэслэлгүйгээр хэтрүүлсэн бол хугацаа хоцорсон хоног тутам ГТН-д тогтоосон хэмжээгээр Зөвлөхөд, Зөвлөх нь гэрээний үүргээ биелүүлээгүй үүргийн үнийн дүнгээр Захиалагчид хүү төлөх ёстай.

7. ШУДАРГА БАЙДАЛ

7.1. Шударга байдал

Талууд энэхүү гэрээний дагуу үйл ажиллагаа явуулахдаа бие биенийхээ эрхийг хүндэтгэн, шударга байдлаар хандах ба гэрээний зорилгыг хэрэгжилтийг хангахын тулд бүхий л зохистой арга хэмжээг авна.

8. МАРГААНЫГ ШИЙДВЭРЛЭХ

8.1 . Маргааныг эв зүйгээр шийдвэрлэх

Маргаанаас зайлсхийх, эсхүл түүнийг цаг алдалгүй шийдвэрлэх нь гэрээний гүйцэтгэлийг сайтар хангах болон төсөл арга хэмжээний амжилтанд ихээхэн чухал гэдгийг талууд хүлээн зөвшөөрнө. Гэрээтэй холбоотой аливаа маргааныг талууд харилцан тохиролцож, эв зүйгээр шийдвэрлэхийг эрмэлзэнэ.

8.2 . Маргааныг шийдвэрлэх

Талууд гэрээний холбоотой аливаа маргааныг эв зүйгээр шийдвэрлэж чадахгүй тохиолдолд аль нэг тал нь ГТН-д заасан маргааныг шийдвэрлэх арга хэрэгслийг сонгох эрхтэй.

----оОо----

ИЛ БОЛСОН

МАШ НУУЦ

II. ХУУЛИЙН ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ
НӨХЦӨЛ



II. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

ГЕН-ийн
дугаар

Нөхцөл

- 1.1. Гэрээнд хэрэглэх хууль нь Монгол улсын хууль тогтоомж, эрх зүйн актууд байна.
- 1.3. Гэрээний баримт бичгүүд нь Монгол хэл дээр байна.
- 1.4. Захиалагчийн хаяг:
Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо, 13 дугаар хороолол,
Нарны зам 62, "Юнион Бюлдинг" Б блок, 11 давхар
Захиалагч: "Тавантолгой төмөр зам" ХХК
Харилцах хүн: Төсөл хөгжлийн газрын дарга Э.Эрдэнэбат
Утас: 77777727
И-мэйл: info@ttz.mn, erdenebat@ttz.mn
- 2.2. Гэрээ байгуулж, гарын үсэг зурсан өдрөөс
- 2.3. Тогтоосон хугацаа: Гэрээ байгуулсанаас хойш 4 жилийн хугацаатай байна.
- 4.1. Зөвлөх нь хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий байгууллагын зөвшөөрөлтэй, барилгын ажил гүйцэтгэх гэрээ болон FIDIC-ийн гэрээг судалсан, туршлагатай хуульчдаас бүрдэнэ. Гадаад ажилтны ажлын төлөвлөгөөг ажлын хэрэгцээг үндэслэн Захиалагчид ирүүлнэ.
- 5.3. (а) Захиалагч нь итгэмжлэгдсэн төлөөлөгчийг тогтвортой суурьшилтай ажиллах тал дээр дотоод бодлого барьж ажиллана.
(б) Захиалагч талын удирдлага өөрчлөгдөхгүй байх, нэгдсэн удирдлагаар ханган ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлэн ажиллана.
(в) Захиалагч нь өөрийн ажилтнуудад Зөвлөхийн үйлчилгээнд хариуцлагатай хандах талаар зохион байгуулалтын арга хэмжээг авах үүрэгтэй.
- 6.1. Гэрээний үнэд Зөвлөх, түүний ажилтнуудын байр, хоол, томилолтын зардал болон ажиллахад шаардлагатай бүхий л зардлууд багтсан байна.
- 6.2. (а) Захиалагч нь гадаад мөнгөн тэмдэгтээр төлбөрийг төлөхгүй.
(б) Төгрөгөөр хийх төлбөрийг зөвхөн Гүйцэтгэгчийн өөрийн дансанд хийнэ.
- 6.4. Төлбөр хийх данс:
Өмгөөллийн "Легал линк Си Би Эй" ХХК Голомт банк 1415119855
Төлбөрийг зөвлөхийн ажлын гүйцэтгэлээр баталгаажуулан тооцно.
- 6.5. Гэрээтэй холбоотой үүссэн маргааныг талууд эв зүйгээр шийдвэрлэж чадахгүй тохиолдолд Монгол улсын шүүхэд хандан шийдвэрлүүлнэ.

ИЛ БОЛСОН

МАШ НУУЦ

"Тавантолгой төмөр зам" ХХК болон Өмгөөллийн "Легал линк Си Би Эй"
ХХН нарын хооронд байгуулсан ... дугаар бүхий "Зөвлөх үйлчилгээ
үзүүлэх гэрээ"-ний Хавсралт-1 Ажлын даалгавар

**ХАВСРАЛТ №1
АЖЛЫН ДААЛГАВАР**



ЗӨВЛӨХ



ГАРЧИГ

1. ЗОРИЛГО.....	2
2. ХАМРАХ ХҮРЭЭ	2
3. ТАЙЛАН ИРҮҮЛЭХ ХУГАЦАА.....	3



1. ЗОРИЛГО

- 1.1. Энэхүү хавсралтын хүрээнд "Тавантолгой төмөр зам"-ийн хэрэгжүүлж буй төсөл болох "Богдхан төмөр зам" төслийн хүрээнд хууль эрх зүйн зөвлөгөө, туслалцаа өгөх, хууль зүйн дүгнэлт боловсруулах, шаардлагатай гэрээ контрактын төсөл боловсруулах, судалгаа шинжилгээ хийх, зөвлөмж өгөх, шаардлагатай тохиолдолд бусад этгээдийн өмнө төлөөлөн зөвлөгөө үйлчилгээ үзүүлэн ажиллана.

2. ХАМРАХ ХҮРЭЭ

- 2.1. "Богдхан төмөр зам" төслийн санхүүжилттэй холбоотой дараах ажлыг гүйцэтгэнэ. Үүнд:
- 2.1.1. Төслийн санхүүжилтийн гэрээний төслийг боловсруулах, гэрээний төсөлд санал хүргүүлэх;
 - 2.1.2. Санхүүжилтийн гэрээний хэрэгжилтийн хүрээнд Санхүүжүүлэгч компани болон Гүйцэтгэгч компанийтай хэлэлцээрт оролцох, хууль зүйн уялдаа холбоог хангах;
- 2.2. "Богдхан төмөр зам"-ын доод бүтэц, өртөө зөрлөгийн барилга угсралтын ажилтай холбоотой дараах ажлыг гүйцэтгэнэ. Үүнд:
- 2.2.1. ФИДИК-ээс гаргасан "Улаан ном"-ыг Монгол хэл дээр орчуулах, бусад албан бус орчуулгуудтай нийцүүлэх;
 - 2.2.2. "Зэвсэгт хүчиний жанжин штаб"-тай байгуулах "Богдхан төмөр зам"-ын доод бүтэц, өртөө зөрлөгийн барилга байгууламж барих гэрээний төслийг боловсруулах, хүргүүлэх;
 - 2.2.3. "Зэвсэгт хүчиний жанжин штаб"-тай байгуулах "Богдхан төмөр зам"-ын доод бүтэц, өртөө зөрлөгийн барилга байгууламжийн ажил гүйцэтгэх Барилга угсралтын ажил гүйцэтгэх гэрээ байгуулах хэлэлцээрт оролцох;
 - 2.2.4. Төмөр замын барилгын ажил эхлүүлэх явцад үүсэх хууль эрх зүйн асуудлыг судалж зөвлөгөө, дүгнэлт өгч ажиллах;
 - 2.2.5. "Богдхан төмөр зам"-ын барилгын ажлын явцад Захиалагчид үүссэн хууль эрх зүйн асуудлаар шаардлагатай дүгнэлт, зөвлөмжийг аман болон бичгэн байдлаар гаргах;
 - 2.2.6. Захиалагчийн зүгээс шаардлагатай гэж үзсэн тохиолдолд Гүйцэтгэгч компани хоорондын уялдаа холбоог хангах үүднээс хууль эрх зүйн дэмжлэг үзүүлэх, холбогдох харилцааг тогтоох;
 - 2.2.7. Барилгын ажилтай холбоотой учирч болзошгүй хууль эрх зүйн эрсдэлийг судалж танилцуулах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх талаар хууль зүйн зөвлөгөө өгч ажиллах;
 - 2.2.8. Шаардлагатай тохиолдолд холбогдох ажлын хэсэгт төлөөлөгчөө томилж ажиллуулах;
- 2.3. "Богдхан төмөр зам"-ын дээд бүтцийн барилга угсралтын ажилтай холбоотой дараах ажлыг гүйцэтгэнэ. Үүнд:
- 2.3.1. "Улаанбаатар Төмөр Зам" ХНН-тэй байгуулах "Богдхан төмөр зам"-ын дээд бүтцийн барилга байгууламж барих гэрээний төслийг боловсруулах,
 - 2.3.2. "Улаанбаатар Төмөр Зам" ХНН-тэй байгуулах "Богдхан төмөр зам"-ын дээд бүтцийн барилга байгууламжийн ажил гүйцэтгэх Барилга угсралтын ажил гүйцэтгэх гэрээ байгуулах хэлэлцээрт оролцох;
 - 2.3.3. Төмөр замын барилгын ажлын цогц төслийн уялдаа холбоог хангах үүднээс Гүйцэтгэгч компанийн гүйцэтгэх ажлыг бусад гүйцэтгэгч нарын ажилтай уялдуулах асуудал дээр хууль эрх зүйн зөвлөгөө, дүгнэлт өгч ажиллах;



Ажилтан:
2023 он. 09. 01. өдөр

- 2.3.4. Төмөр замын дээд бүтцийн барилгын ажлын явцад Захиалагчид үүссэн хууль эрх зүйн асуудлаар шаардлагатай дүгнэлт, зөвлөмжийг аман болон бичгэн байдлаар гаргах;
- 2.3.5. Захиалагчийн зүгээс шаардлагатай гэж үзсэн тохиолдолд Гүйцэтгэгч компани хоорондын уялдаа холбоог хангах үүднээс хууль эрх зүйн дэмжлэг үзүүлэх, холбогдох харилцааг тогтоох;
- 2.3.6. Барилгын ажилтай холбоотой учирч болзошгүй хууль эрх зүйн эрсдэлийг судалж танилцуулах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх талаар хууль зүйн зөвлөгөө өгч ажиллах;
- 2.3.7. Шаардлагатай тохиолдолд холбогдох ажлын хэсэгт төлөөлөгчөө томилж ажиллуулах;
- 2.4. “Богдхан төмөр зам”-ын эстакадан гүүр, туннелын барилга угсралтын ажилтай холбоотой дараах ажлыг гүйцэтгэнэ. Үүнд:
- 2.4.1. “Бодь Интернешнл” ХХК-тай байгуулах ЕРС гэрээний төслийг боловсруулах, Гүйцэтгэгч талтай хийх хэлэлцээрт оролцох;
 - 2.4.2. Төмөр замын барилгын ажлын цогц төслийн уялдаа холбоог хангах үүднээс Гүйцэтгэгч компанийн гүйцэтгэх ажлыг бусад гүйцэтгэгч нарын ажилтай уялдуулах асуудал дээр хууль эрх зүйн зөвлөгөө, дүгнэлт өгч ажиллах;
 - 2.4.3. “Богдхан төмөр зам”-ын барилгын ажлын явцад Захиалагчид үүссэн хууль эрх зүйн асуудлаар шаардлагатай дүгнэлт, зөвлөмжийг аман болон бичгэн байдлаар гаргах;
 - 2.4.4. Захиалагчийн зүгээс шаардлагатай гэж үзсэн тохиолдолд Гүйцэтгэгч компани хоорондын уялдаа холбоог хангах үүднээс хууль эрх зүйн дэмжлэг үзүүлэх, холбогдох харилцааг тогтоох;
 - 2.4.5. Барилгын ажилтай холбоотой учирч болзошгүй хууль эрх зүйн эрсдэлийг судалж танилцуулах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх талаар хууль зүйн зөвлөгөө өгч ажиллах;
 - 2.4.6. Шаардлагатай тохиолдолд холбогдох ажлын хэсэгт төлөөлөгчөө томилж ажиллуулах;
- 2.5. “Богдхан төмөр зам”-ын төслийг “Улаанбаатар зам” ХНН-д хүлээлгэн өгөх, ашиглалтад оруулахтай холбоотой дараах ажлыг гүйцэтгэнэ. Үүнд:
- 2.5.1. “Богдхан төмөр зам”-ын төслийн ажлыг хүлээлгэн өгөх, ашиглалтад оруулахтай холбоотой техникийн болон улсын комисс ажиллахад шаардлагатай Захиалагчийн холбогдох баримт бичгийг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх;
 - 2.5.2. Засгийн газрын тогтоолын дагуу “Богдхан төмөр зам”-ыг “Улаанбаатар төмөр зам” ХНН-д шилжүүлэн өгөхөд Захиалагчид шаардлагатай баримт бичиг боловсруулах, холбогдох зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх;
 - 2.5.3. Гүйцэтгэгч нарын гүйцэтгэсэн ажлын уялдаа холбоог хангуулах талаар Захиалагчид шаардлагатай дэмжлэг, хууль зүйн туслалцаа үзүүлэх;
 - 2.5.4. Байгаль орчны нөхөн сэргээлт, төрийн нууцын мэдээ, мэдээллийг хүлээлгэн өгөх асуудал дээр хууль эрх зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх;
 - 2.5.5. “Богдхан төмөр зам”-ын төслийн ажлыг компанийн тайлан балансад хэрхэн бүртгэх талаар хууль зүйн зөвлөгөө, мэдээлэл өгөх.

3. ТАЙЛАН ИРҮҮЛЭХ ХУГАЦАА

- 3.1. Сар бүрийн гүйцэтгэсэн ажлын тайланг дараа сарын 05-ны өдөр хүргүүлнэ.
- 3.2. Эцсийн тайланг гэрээт ажлын хугацаа дууссанаас хойш ажлын 10 өдрийн дотор ирүүлж, Захиалагчаар баталгаажуулах.



4. ЗӨВЛӨХӨД ТАВИГДАХ ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

- 4.1. ФИДИК-ийн гэрээ дээр ажиллаж байсан туршлагатай мэргэжилтнүүд багийн гишүүдийн 50 хувиас багагүй байх.
- 4.2. Зөвлөх багийн бүрэлдэхүүнд шаардлагатай тохиолдолд гадаадын зөвлөх ажиллах.
- 4.3. Шаардлагатай тохиолдолд Ажлын даалгаварт заагдсан ажил болон тухайлсан үйл ажиллагааны нарийвчилсан төлөвлөгөө боловсруулж, Захиалагчаар батлуулах.
- 4.4. Зөвлөхийн багийн гишүүдийн танилцуулга, удирдлага зохион байгуулалт болон чиг үүргийг доорх хүснэгтэд үзүүлэв.



Багийн ахлагч
Л.Отгонбаяр



Багийн дэд ахлагч
Б.Батсэлэнгэ



Багийн дэд ахлагч
М.Шинэбаяр



Хуульч
Н.Мөнхтуяа



Хуульч
С.Цэлмөг



Хуульч
А.Сэргөлзонтuyaа



Зөвлөх
Б.Амарсанаа



Мэргэжилтэн
Э.Тогтохголдор



Мэргэжилтэн
Ж.Цолмон



Мэргэжилтэн
Э.Мөнхсайхан



Зөвлөх
Н.Одгэрэл



Мэргэжилтэн
Н.Нинжбадгар



Мэргэжилтэн
Н.Алтанзор



**НӨХӨРЛӨЛИЙН УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ,
БАГИЙН ГИШҮҮДИЙН ЧИГ ҮҮРЭГ**

№	Нэр, гишүүнчлэл, зэрэг цол	Баг доторх статус	Хариуцах ажил (Мэргэжилтний ажил доор дурдсанаар хязгаарлагдахгүй)
1.	Л.Отгонбаяр (LL.M, Edinburgh) /Монголын Хуульчдын Холбооны гишүүн, өмгөөлөгч, Шанхайн Олон Улсын Худалдаа, Эдийн засгийн Арбитрын Комиссын арбитрч, СЗХ-ноос Үнэт заасны зах зээлд хууль зүйн зөвлөгөө өгөх эрх авсан/	Багийн ахлагч (Ерөнхий зөвлөх)	<ul style="list-style-type: none"> Багийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, үйлчлүүлэгчийн өмнө төлөөлөх Багийн гишүүдийн статусыг тодорхойлох, ажил үүргийг хуваарилан зохицуулах
2.	М.Шинэбаяр (MBA, Taiwan) /Монголын Хуульчдын Холбооны гишүүн, өмгөөлөгч, СЗХ-ноос Үнэт заасны зах зээлд хууль зүйн зөвлөгөө өгөх эрх авсан, Монголын Олон Улсын Арбитрын Ерөнхий нарийн бичгийн дарга/	Багийн дэд ахлагч	<ul style="list-style-type: none"> EPC гэрээтэй холбоотой гэрээ, эрх зүйн баримт бичиг, зөвлөгөө үйлчилгээг хариуцах Багийн ахлагчийн эзгүйд орлох
3.	Б.Батсэлэнгэ (MA) /Монголын Хуульчдын Холбооны гишүүн, өмгөөлөгч, Монголын Олон Улсын Арбитрын арбитрч, СЗХ-ноос Үнэт	Багийн дэд ахлагч	<ul style="list-style-type: none"> Санхүүжилтийн гэрээ, хувьцаа, санхүүжилтийн схемтэй холбоотой ажлыг хариуцах Өдөр тутмын эрх зүйн зөвлөгөө, гэрээ эрх зүйн баримт бичгийн боловсруулалт Багийн ахлагчийн эзгүйд орлох

	заасны зах зээлд хууль зүйн зөвлөгөө өгөх эрх авсан/		<ul style="list-style-type: none"> Хууль зүйн магадлан шинжилгээ, хууль зүйн дүгнэлт боловсруулах багийн гишүүдийг ахлан ажиллах
4.	Б.Амарсанаа /LLD – Nagoya, Монголын Хуульчдын Холбооны гишүүн, хуульч, өмгөөлөгч, МУИС-ийн профессор/	Судалгааны зөвлөх	<ul style="list-style-type: none"> Эрх зүйн судалгааны арга зүй, хууль тогтоомжийн харьцуулалт, хувийн эрх зүй, гэрээний эрх зүй, олон улсын эрх зүйн чиглэлээр зөвлөгөө өгөх, судалгаа хийх
5.	А.Сэргэлэнтуяа /LL.M - Pen.State, Монголын Хуульчдын холбооны гишүүн, хуульч, өмгөөлөгч, СЗХ-ноос Үнэт заасны зах зээлд хууль зүйн зөвлөгөө өгөх эрх авсан/	Зөвлөх	<ul style="list-style-type: none"> Санхүүжилтийн гэрээ, хувьцаа, санхүүжилтийн схемтэй холбоотой ажлыг хариуцах Өдөр тутмын эрх зүйн зөвлөгөө, гэрээ эрх зүйн баримт бичгийн боловсруулалт Багийн дэд ахлагчийн эзгүйд орлох Хууль зүйн магадлан шинжилгээ, хууль зүйн дүгнэлт боловсруулах багийн гишүүдийг ахлан ажиллах
6.	Н.Мөнхтуяа /Монголын Хуульчдын Холбооны гишүүн, өмгөөлөгч, СЗХ-ноос Үнэт заасны зах зээлд хууль зүйн зөвлөгөө өгөх эрх авсан/	Багийн ахлах хуульч	<ul style="list-style-type: none"> Багийн өдөр тутмын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх Өдөр тутмын эрх зүйн зөвлөгөө, гэрээ эрх зүйн баримт бичгийн боловсруулалт Багийн дэд ахлагчийн эзгүйд орлох Хууль зүйн магадлан шинжилгээ, хууль зүйн дүгнэлт боловсруулах багийн гишүүдийг ахлан ажиллах
7.	Э.Цэлмэг / Монголын Хуульчдын Холбооны гишүүн /	Багийн туслах	<ul style="list-style-type: none"> Багийн өдөр тутмын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх
8.	Э.Төгстөгөлдөр /Эрх зүйч/	Багийн туслах	<ul style="list-style-type: none"> Багийн өдөр тутмын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх
9.	Ж.Цолмон /Эрх зүйч, нягтлан бодогч/	Багийн туслах	<ul style="list-style-type: none"> Багийн өдөр тутмын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх

10.	Э.Мөнхсайхан /Эрх зүйч/	Багийн туслах	➤ Багийн өдөр тутмын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх
11.	Н.Одгэрэл /Санхүүч, эдийн засагч, Татварын итгэмжлэгдсэн зөвлөх/	Багийн зөвлөх	➤ Багийн өдөр тутмын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх
12.	Н.Алтансор /Эрх зүйч/	Багийн туслах	➤ Багийн өдөр тутмын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх

--000000000--



ХАВСРАЛТ №2
АЖЛЫН КАЛЕНДАРЧИЛСАН ТӨЛӨВЛӨГӨӨ



ЗӨВЛӨХ

10

“Богдхан төмөр зам”-ын барилгын ажилд хууль зүйн үйлчилгээ үзүүлэн ажлын эхний жилийн календарчилсан төлөвлөгөө

- Ажлын календарчилсан төлөвлөгөөг 1 (нэг) жилийн хугацаатайгаар доорх хүснэгтэд үзүүлэв. Зөвлөх нь Ажлын календарчилсан төлөвлөгөөг жил бүр шинэчлэн Захиалагчаар батлуулна.

Д/д	Гүйцэтгэх ажил	2022 он												2023 он																																			
		7				8				9				10				11				12				1				2				3				4				5				6			
		1	2	3	4	1	2	3	4	1	2	3	4	1	2	3	4	1	2	3	4	1	2	3	4	1	2	3	4	1	2	3	4	1	2	3	4												
1	“Богдхан төмөр зам” төслийн санхүүжилтийн холбоотой																																																
1.1	Төслийн санхүүжилтийн гэрээний төслийг боловсруулах, гэрээний төсөлд санал хургуулэх;																																																
1.2	Санхүүжилтийн гэрээний хэрэгжилтийн хүрээнд компани болон Гүйцэтгэгч компанийн хэлэлцээрт оролцох, хууль зүйн уялдаа холбоог хангах;																																																
2	“Богдхан төмөр зам”-ын доод бүтэц, өртөө зэрлэгийн барилга ажилтай																																																
2.1	ФИДИК-ээс гаргасан “Улаан ном”-ыг Монгол хэл дээр орчуулах, бусад албан бус орчуулгуудтай нийцүүлэх;																																																
2.2	Зэвсэгт хучний жанжин штабтай байгуулах “Богдхан төмөр зам”-ын доод бүтэц, өртөө зэрлэгийн барилга байгууламж барих гэрээний төслийг боловсруулах, Гүйцэтгэгч талтай хийх хэлэлцээрт оролцох;																																																

ЗАХИАЛАГЧ





	бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх;	
5.2	Засгийн газрын тогтоолын дагуу "Богдхан төмөр зам"-ыг "Улаанбаатар төмөр зам" ХНН-д шилжүүлэн өгөхэд Захиалагчид шаардлагатай баримт бичиг боловсруулах, холбогдох зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх;	
5.3	Гүйцэтгэч нарын гүйцэтгэсэн ажлын уялдаа холбоог хангуулах талаар Захиалагчид шаардлагатай дэмжлэг, хууль зүйн туспалцаа үзүүлэх;	
5.4	Байгаль орчны нэжөн сэргээлт, тэрийн нуудын мэдээ, мэдээллийг хүлээлгэн өгөх асуудал дээр хууль эрх зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх.	
5.5	"Богдхан төмөр зам"-ын төслийн ажлыг компанийн тайлан балансад хэрхэн бүртгэх талаар хууль зүйн зөвлөгөө, мэдээлэл өгөх.	

ХАВСРАЛТ №3
ГЭРЭЭНИЙ ТӨЛБӨР, ТӨЛБӨРИЙН ХУВААРЬ



зэвлэх
10

ГАРЧИГ

1. ГЭРЭЭНИЙ ТӨЛБӨР 2
2. ТӨЛБӨРИЙН ХУВААРЬ 2
3. ТӨЛБӨРИЙН НЭХЭМЖЛЭХ..... 3



1. ГЭРЭЭНИЙ ТӨЛБӨР

- 1.1. Энэхүү гэрээний төлбөрийн үүрэг нь зөвлөх үйлчилгээний ажлын даалгаварт заасан ажил, түүний гүйцэтгэл, хэм хэмжээнээс шууд хамаарна. Ажлын даалгаварт заасан ажлыг төлбөрийн хуваарьтай уялдуулан, гүйцэтгэлээр үнэлэх аргачлалыг Захиалагч тодорхойлно.
- 1.2. Зөвлөх үйлчилгээний нийт төлбөр нь 11 115 000 000 /арван нэгэн тэрбум нэг зуун арван таван сая төгрөг/ төгрөг байна. Энэхүү дүнд НӨАТ орсон дүн байна.
- 1.3. Зөвлөхийн ирүүлсэн тайланг Захиалагчаас томилогдсон эрх бүхий ажлын хэсгийн хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэж, дүгнэлт гаргасны үндсэн дээр хуваарьт төлбөрийг улирал бүр төлбөрийн нэхэмжлэлийн үндсэн дээр шилжүүлнэ.

2. ТӨЛБӨРИЙН ХУВААРЬ

2.1. Төлбөрийн хуваарь доорх хүснэгтэд үзүүлэв.

№	Төлбөрийн хуваарь	Х.нэгж	Дүн	Эзлэх хувь
1	Захиалагч нь 2022 оны эхний улирлаас эхлэн урьдчилгаа төлбөр төлөлгүйгээр төслийг эхлүүлэх, гэрээ хэлэлцээр хийх, хууль зүйн судалгаа, дүгнэлтийн ажил гүйцэтгүүлсэн тул ажлын гүйцэтгэлийг үнэлж нийт үнийн дүнгээс ажилд эзлэх хувиар тооцон төлбөрийг ажлыг хүлээн авсны дараа гүйцэтгэгчийн нэхэмжлэхийг үндэслэн шилжүүлнэ.	мян.төгрөг	2.778.750	25%
2	Гүйцэтгэгчээс ирүүлсэн 2023 оны 1 дүгээр улирлын тайланг үндэслэн Зөвлөхийн нэхэмжлэлийн дагуу шилжүүлнэ.	мян.төгрөг	833.625	7.5%
3	Гүйцэтгэгчээс ирүүлсэн 2023 оны 2 дугаар улирлын тайланг үндэслэн Зөвлөхийн нэхэмжлэлийн дагуу шилжүүлнэ.	мян.төгрөг	833.625	7.5%
4	Гүйцэтгэгчээс ирүүлсэн 2023 оны 3 дугаар улирлын тайланг үндэслэн Зөвлөхийн нэхэмжлэлийн дагуу шилжүүлнэ.	мян.төгрөг	833.625	7.5%
5	Гүйцэтгэгчээс ирүүлсэн 2023 оны 4 дугаар улирлын тайланг үндэслэн Зөвлөхийн нэхэмжлэлийн дагуу шилжүүлнэ.	мян.төгрөг	833.625	7.5%
6	Гүйцэтгэгчээс ирүүлсэн 2024 оны 1 дүгээр улирлын тайланг үндэслэн Зөвлөхийн нэхэмжлэлийн дагуу шилжүүлнэ.	мян.төгрөг	833.625	7.5%



7	Гүйцэтгэгчээс ирүүлсэн 2024 оны 2 дугаар улирлын тайланг үндэслэн Зөвлөхийн нэхэмжлэлийн дагуу шилжүүлнэ.	мян.төгрөг	833.625	7.5%
8	Гүйцэтгэгчээс ирүүлсэн 2024 оны 3 дугаар улирлын тайланг үндэслэн Зөвлөхийн нэхэмжлэлийн дагуу шилжүүлнэ.	мян.төгрөг	833.625	7.5%
9	Гүйцэтгэгчээс ирүүлсэн 2024 оны 4 дүгээр улирлын тайланг үндэслэн Зөвлөхийн нэхэмжлэлийн дагуу шилжүүлнэ.	мян.төгрөг	833.625	7.5%
10	Гүйцэтгэгчээс ирүүлсэн 2025 оны 1 дүгээр улирлын тайланг үндэслэн Зөвлөхийн нэхэмжлэлийн дагуу шилжүүлнэ.	мян.төгрөг	416.812,5	3.75%
11	Гүйцэтгэгчээс ирүүлсэн 2025 оны 2 дүгээр улирлын тайланг үндэслэн Зөвлөхийн нэхэмжлэлийн дагуу шилжүүлнэ.	мян.төгрөг	416.812,5	3.75%
	Гүйцэтгэгчээс ирүүлсэн 2025 оны 3 дүгээр улирлын тайланг үндэслэн Зөвлөхийн нэхэмжлэлийн дагуу шилжүүлнэ.	мян.төгрөг	416.812,5	3.75%
	Гүйцэтгэгчээс ирүүлсэн 2025 оны 4 дүгээр улирлын тайланг үндэслэн Зөвлөхийн нэхэмжлэлийн дагуу шилжүүлнэ.	мян.төгрөг	416.812,5	3.75%
	Нийт		11.115.000 000	100%

3. ТӨЛБӨРИЙН НЭХЭМЖЛЭЛ

- 3.1. Зөвлөх нь эрх бүхий ажлын хэсгийн хуралдааны шийдвэр гарснаас хойш төлбөрийн нэхэмжлэлийг Захиалагчид хүргүүлэх бөгөөд Захиалагч 7 хоногийн дотор нэхэмжлэлд заасан дансруу төлбөрийг шилжүүлнэ.

--oo0o0oo0oo--



**БОГДХАН ТӨМӨР ЗАМ ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХУУЛИЙН ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛСЭН
АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ТАЙЛАНГИЙН ГҮЙЦЭТГЭЛ БАТАЛГААЖУУЛСАН АКТ**

/Захиалагчийн шаардлагаар шинээр гүйцэтгэсэн ажил/

1. ЕРӨНХИЙ ЗААЛТ

- “Тавантолгой төмөр зам” ХХК-ийн Гүйцэтгэх захирлын 2022 оны 08 дугаар сарын 08-ны өдрийн А/137 дугаар тушаалаар байгуулагдсан Богдан төмөр зам төслийн худалдан авалт хариуцсан Ажлын хэсгийн 2022 оны 08 дугаар сарын 26-ны өдрийн хурлын 03 дугаар зөвлөмж;
- “Тавантолгой төмөр зам” ХХК-ийн Гүйцэтгэх захирлын 2022 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн А/20 дугаар тушаалаар байгуулагдсан Төслийн удирдах хорооны 8 дугаар сарын 30-ны өдрийн шийдвэр;
- “Тавантолгой төмөр зам” ХХК боло Өмгөөллийн “Легал линк Си Би Эй” ХХН хооронд байгуулсан 2022 оны 8 дугаар сарын 30-ны өдрийн АГГ-ТТЗ-МН22/06 дугаар гэрээний календарьчилсан төлөвлөгөөг тус тус үндэслэв.

Гэрээний нэр	Хуулийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх гэрээ
Гэрээний дугаар	АГГ-ТТЗ-МН-22/06
Захиалагч байгууллага	“Тавантолгой төмөр зам” ХХК
Гүйцэтгэгч байгууллага	Өмгөөллийн “Легал линк Си Би Эй” ХХН
Гэрээ байгуулсан огноо	2022.08.30
Гэрээгээр ажил дуусах хугацаа	2026.08.30
Гэрээгээр гүйцэтгэсэн ажил баталгаажуулах тайлант хугацаа	2022.01.01-2022.08.05

2. КАЛЕНДАРЬЧИЛСАН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Д/д	Гүйцэтгэх ажил	Эзлэх хувь	Гүйцэтгэсэн ажил	Биелэлт /хувиар/
1 “Богдан төмөр зам” төслийн санхүүжилттэй холбоотой				
1.1	Төслийн санхүүжилтийн гэрээний төслийг боловсруулах, гэрээний төсөлд санал хүргүүлэх;	4%	Төслийн санхүүжилтийн гэрээний төслийг боловсруулж ЭТТ хүргүүлсэн бөгөөд ЭТТ-ээс ирүүлсэн гэрээний төсөлд санал хүргүүлсэн.	93%
1.2	Санхүүжилтийн гэрээний хэрэгжилтийн хүрээнд Санхүүжүүлэгч компани болон Гүйцэтгэгч компанийн хэлэлцээрт оролцох, хууль зүйн уялдаа холбоог хангах;	1% 1%	“Богдан төмөр зам” төслийн ажлын санхүүжилт болон гэрээнд оролцогч талуудттай холбоотой хууль зүйн дүгнэлт Санхүү төсвийн мэргэжилтэнтэй байгуулах гэрээний төсөл болон Ажлын даалгавар	95% 94%
2 “Богдан төмөр зам”-ын доод бүтэц, өртөө зэрлэгийн барилга угсралтын ажилтай холбоотой				




2.1	ФИДИК-ээс гаргасан "Улаан ном"-ыг Монгол хэл дээр орчуулах, бусад албан бус орчуулгуудтай нийцүүлэх;	5%	ФИДИК-ээс гаргасан "Улаан ном"-ыг Монгол хэл дээр орчуулах	90%
2.2	Зэвсэгт хүчний жанжин штабтай байгуулах "Богдхан төмөр зам"-ын доод бүтэц, өртөө зөрлөгийн барилга байгууламж барих гэрээний төслийг боловсруулах, Гүйцэтгэгч талтай хийх хэлэлцээрт оролцох;	4%	Зэвсэгт хүчний жанжин штабтай байгуулах "Богдхан төмөр зам"-ын доод бүтэц, өртөө зөрлөгийн барилга байгууламж барих гэрээний Ерөнхий хэлэлцээр, Тусгай нөхцөл, Хавсралтуудын төслийг боловсруулж хүргүүлсэн бөгөөд Гүйцэтгэгч талаас ирүүлсэн санал дээр ярилцаж, Гүйцэтгэгчтэй гэрээ байгуулах хэлэлцээрт оролцсон	100%
2.3	Төмөр замын барилгын ажил эхлүүлэх явцад үүсэх хууль эрх зүйн асуудлыг судалж зөвлөгөө, дүгнэлт өгч ажиллах;	1%	"Богдхан төмөр зам" төслийн ерөнхий гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагаатай холбоотой хууль зүйн товч дүгнэлт холбогдох хавсралт албан бичгийн төслийн хамт боловсруулж хүргүүлсэн.	96%
		1%	"Богдхан төмөр зам"-ын төсөлд шаардлагатай түгээмэл тархацтай ашигт малтмалын судалгаа, ус ашиглалтын зөвшөөрөлтэй холбоотой хууль зүйн дүгнэлт холбогдох хавсралт албан бичгийн төслийн хамт боловсруулж хүргүүлсэн.	98%
		1%	"Богдхан төмөр зам" төслийн газар чөлөөлөлт, зарцуулагдах нөхөх олговортой холбоотой хууль зүйн дүгнэлт боловсруулж хүргүүлсэн.	97%
		1%	"Богдхан төмөр зам" төслийг эхлүүлэх, бэлтгэл ажлыг хангах хүрээнд авах арга хэмжээний тухай санал зөвлөмж холбогдох хавсралт албан бичгийн төслийн хамт боловсруулж хүргүүлсэн.	95%
3	"Богдхан төмөр зам" -ын дээд бүтцийн барилга угсралтын ажилтай холбоотой			

3.1	"Улаанбаатар Төмөр Зам" ХНН-тэй байгуулах "Богдхан төмөр зам"-ын дээд бүтцийн барилга байгууламж барих гэрээний төслийг боловсруулах, Гүйцэтгэгч талтай хийх хэлэлцээрт оролцох;	2%	"Улаанбаатар төмөр зам" ХНН-тэй байгуулах "Богдхан төмөр зам"-ын дээд бүтцийн барилга байгууламж барих гэрээний төслийг боловсруулах, Гүйцэтгэгч талтай хийх хэлэлцээрт оролцох;	90%
4	"Богдхан төмөр зам"-ын эстакадан гүүр, туннельн барилга угсралтын ажлын хүрээнд:			
4.1	"Бодь Интернешнл" ХХК-тай байгуулах "Богдхан төмөр зам"-ын барилга угсралтын ажил гүйцэтгэх гэрээний төслийг боловсруулах, Гүйцэтгэгч талтай хийх хэлэлцээрт оролцох;	4%	"Бодь интернешнл" ХХК-тай байгуулах "Богдхан төмөр зам"-ын туннель, эстикадан гүүрийн барилга байгууламж барих гэрээний иж бүрдлийн төслийг боловсруулах, Гүйцэтгэгч талтай хийх хэлэлцээрт оролцсон.	90%
4.2				
Нийт эзлэх хувь		25%	Биелэлт тооцсон хувь	93.5%

3. ТАЙЛАНГИЙН ГҮЙЦЭТГЭЛ БАТАЛГААЖУУЛСАН

Талуудын хооронд байгуулсан гэрээний ерөнхий нэхцэлийн 3.6, гэрээний №1 дүгээр хавсралтаар батлагдсан ажлын даалгаврын 4.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Зөвлөх болох Өмгөөллийн "Легал линк Си Би Эй" ХХН нь Төмөр замын барилгын ажилд хуулийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх гэрээний календарьчилсан төлөвлөгөөний дагуу хийж гүйцэтгэсэн тайлангийн гүйцэтгэлийн эзлэх хувь 25% /хорин тав/ бөгөөд гүйцэтгэсэн ажлын биелэлт дунджаар 93.5% /ерэн гурав аравны таван/ хувь гүйцэтгэсэн гэж дүгнэв.

Захиалагчийг төлөөлж:

"Тавантолгой төмөр зам" ХХК-Төсөл, хөгжлийн газрын дарга

Э.ЭРДЭНЭБАТ/

2022 оны 08 дугаар сарын-ны/ний өдөр

Зөвлөхийг төлөөлж:

Өмгөөллийн "Легал линк Си Би Эй" ХХН-ийн Гүйцэтгэх захирал

6006645 6006645/СВА750

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

ТӨСЛИЙН УДИРДАХ ХОРООНЫ ХУРЦЫН ШИЙДВЭР

2022 оны 7 дугаар сарын 29-тэй отор

Улаанбаатар хот

“Тавантолгой төмөр зам” ХХК-ийн төслийн ууриадах хэрэгжүүлэх курлын 2022 оны 7 дугаар сарын 29-ний өдрийн ... дугаар хуралдаан.

ХЭЛСҮҮЛСЭН нь:

- "Легал линк си би эй" ХХН-ий ажлын төслийн нийтийн нацональный стандартын нэмэлт өөрчлөлт оруулж гэрээг сунгах, нэмэлт төлбөрийн шийдвэрлүүлэх.

ШИЙДВЭРЛЭСЭН нь:

Төслийн удирдах хорооны хүрэлцүү тараас

Б.Болор-Эрдэнэ

• 110 кснер

Нарийн бичгийн дарал

11. Түвшинбаяр

Сүйнээшийн газрын дарга

泰國語

Түүхэдтэйн газрын дарга

ГИУНЧА

Я Намерай

Бүрчтүлэгчийн цэдэлгэсэн газрын дарга

ΕΠΟΙΗΣΗΣ

Түшнүүчлөгчүүлүгүнүүсүн салынчулуктар

Э Эрдэнэбаян

Түүхийн газрын дарга

БЭХҮЕ

ЦИЖИЛГЭЭ, УНЭЛГЭЭ, ДОТООД

gabarit Metagame